

**ДУУЛАЛТ ЖҮЖИГ ХИЙГЭЭД  
“ГООЛИНГОО” ХЭМЭЭХ ДУУНЫ УЧРЫГ МӨШГИХ НЬ**

**Б. Хишигсүх \***

Урлаг, уран зохиолын төрөл зүйлүүд өөр өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой хөгжиж ирсэн түүхтэй. Нүүдлийн соёл иргэншилтэй, амьдралын өвөрмөц нөхцөл байдлын дунд олон зуун жилийн турш амьдарч, түүхийн хөгжлийн урт удаан хугацааны явцдаа ахуй амьдрал, аж байдлын арвин баялаг туршлага хуримтлуулж ардын дуу, хуурыг буй болгосон үндэстэн бол Монголчууд юм. Монгол ардын дууны судалгааны хүрээнд эрдэмтэн, судлаач Ц.Дамдинсүрэн, Б.Ренчин, Д.Цэрэнсодном, Х.Сампилдэндэв нарын зэрэг хүмүүс дууны шүлгийн талаас нь сурвалжлан цуглуулж, Д.Дашдорж, Ц.Далай, Х.Ишжамц, Л.Жамсран, Т.Бавуудорж нар дууны түүхийн талаас нь, Ж.Бадраа, У.Загдсүрэн, Г.Ренчинсамбуу, С.Цоодол, Г.Бадрах нар аялгуу, айзам талаас нь тус тус судалж ирсэн уламжлалыг хөгжүүлж, эрдэмтэн, судлаачид Д.Оюунцэцэг, Р.Оюунбат, Л.Эрдэнэчимэг, Ж.Энэбиш, Л.Оюунчимэг, С.Соронзонболд нарын судалгааны бүтээл нэгэнтээ олны хүртээл болсон байна. Монголчуудын дуу хуур, хөгжим судлалын асуудлаар Оросын эрдэмтэн А.Позднеев 1880 онд бичсэн “Монголчуудын ардын дуу”, А.Д.Руднеев, П.И.Берлинский, И.Устюжников, Борис Смирнов, С.А.Кондратеев, Германы эрдэмтэн Н.Н.Поппегийн 1955 онд бичсэн 20 орчим дууны шүлгийн орчуулга, Можарын эрдэмтэн Д.Лоренц, Джорж Кара, Францын эрдэмтэн А.Мостаэрт нарын судалгааг бас дурдах нь зүйтэй болов уу.

Монголын уран зохиолын хөгжлийн түүхэнд жүжгийн зохиол эртнээс үүсэн хөгжиж ирсэн бөгөөд ялангуяа дуулалт жүжиг өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Дуулалт жүжиг буюу аялгуут жүжиг нь эртний дорно дахин ялангуяа эртний нанхиадын соёлд өөрийн гэсэн түүхэн байр суурьтай. Энэ нь “ший” (𐠰𐠣) буюу үндэсний хөгжимт жүжиг. Нанхиадын үндэсний хөгжимт жүжиг нь дуулах, ярих, хөдөлгөөн, тулааны урлаг дээр үндэслэсэн урлагийн өвөрмөц төрөл юм. Нанхиадад 300 гаруй төрлийн хөгжимт жүжиг байдгаас ихэнх нь орон нутгийн шинжтэй байдаг байна. Харьцангуй түгээмэл дэлгэрсэн нь “Бээжин ший” юм. “Ший”-д оролцон тоглогчдыг эрэгтэй, эмэгтэй, эерэг, сөрөг талын дүр хэмээн дөрөв хувааж үздэг. Хөг, аялгуу их олон янз байдаг нь ихээхэн өвөрмөц юм. Жүжиглэлтийн хувьд жүжигчдээс маш их ур чадвар шаарддаг төрөл ажээ. Жүжгийн үйл явдал орон зай, цаг хугацааны хязгаарт баригддаггүй, нөхцөлт зохиомж, бэлгэдэл, хийсвэр дүрслэлийг илүү түлхүү ашигладаг. Бээжин ший-г тавихад хуур,

\* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Утга зохиолын тэнхим

хэнгэрэг зэрэг хөгжмийн зэмсгийг тоглуулдаг. Нанхиадын “ший” (戏) жүжгийн урлаг нь хожуу үеийн дуулалт жүжгийн хөгжих таатай үндэс суурь болж өгсөн байна.



Нанхиадын ший жүжиг нь түүхэн урт удаан хугацааны хөгжлийг туулж Юан гүрний (1206—1368) үед "Юаны дуулалт жүжиг" бүрэлдэж хөгжихөд ихээхэн түлхэц болсон байна. Юаны дуулалт жүжиг нь дуу, хөгжим, бүжиг, жүжиглэлт, дуут жүжгийн яриа зэргийг ихээхэн хөгжүүлсэн байдаг.

元杂剧的兴盛，使元代成为中国戏曲史上的黄金时代，当时有姓名记载的杂剧作家就有200多位，有记载可查的杂剧剧本有700多。元杂剧从多方面反映了当时的社会现实，表达了人民大众反抗压迫、追求美好生活的愿望。

Юан улсын үеийн дуулалт жүжгийн тухайд эрдэмтэн, судлаачид “Жүжгийн зохиолын шижир алтан үе” хэмээн онцлон тэмдэглэсэн бөгөөд эдүгээ тухайн цаг үеийн дуулалт жүжгийн зохиолуудаас бидний үед нийт 200 гаруй бүтээл уламжлагдаж ирсэн гэдэг.

Одоо бидэнд мэдэгдэж байгаагаар бол Юан гүрний үед жүжгийн зохиолын хөгжил дээд цэгтээ хүрч, суурин соёл иргэншлийн жишгээр ялангуяа ордны уран зохиолын хүрээнд ихээхэн дэлгэрлийг олсон бөгөөд нэртэй төлөөлөгч болох Гуань Ханьцин бол Юан улсын хамгийн нэртэй жүжгийн зохиолч юм. Тэрбээр 60 гаруй жүжиг бичсэнээс өдгөө 18 нь уламжлагдаж ирсэн байна. Гуань Ханьцин-гийн ихэнх жүжиг нь эгэл бүсгүйчүүдийн хүнд бэрх амьдрал, нийгмийн бусармаг үйлийг эсэргүүцсэн эсэргүүцэл, хурц ухаан, эрэмгий зүрх зоригийг үзүүлдэг. Түүний "Доу Э-гийн гомдол" буюу "Зуны дунд сарын цас" хэмээх жүжиг нь дорно дахины алдартай эмгэнэлт жүжиг юм. Сайхан сэтгэлт бүсгүй Доу Э эцгийнхээ өрийн төлөөсөнд хорон санаат, мөнгө хүүлэгч Цай авгайн бэр болж улмаар цэл залуудаа бэлэвсэн хоцорч, хорт үйлийн явуулгаар төрийн шоронд хоригдож эцэс сүүлд нь хэлмэгдэж цаазлагддаг билээ. Доу Э бүсгүй цаазын газарт хүргэгдэн ирж, “их цус асгарч, зуны улирал цас орж, сүүлийн гурван жил их гай гаймшиг болно” хэмээн гашуудан зөгнөж хэлсэн нь биелэлээ олдог юм. Эмгэнэлт жүжгийн хурц өгүүлэмжээр зохиолч тухайн цаг үеийн нийгмийн байдлыг шүүмжлэн үзүүлж, улмаар хятадын уран зохиол дахь жүжгийн зохиолын төрөл зүйлийн хөгжилд үлэмжхэн хувь нэмэр оруулсан төдийгүй дэлхийн уран зохиолын сан хөмрөгт өөрийн байр суурийг үлдээсэн сайн бүтээлийг туурвиж чадсан зохиолч билээ. Мөн зохиолч Ван Шипу нийт 14 жүжгийн зохиол бичсэн байдгаас түүний бичсэн "Ши Шянжи бичиг" бол Хятадын жүжгийн түүхэнд эртний сонгодог бүтээл болохынхоо хувьд ихээхэн алдартай билээ. Уг жүжигт Цүй Инин, Зэн Шэн нарын янаг дурлалын тухай өгүүлж, тэдний хайр дурлалынхаа төлөө тэмцэн байж ураг барилдах гэсэн хүсэл тэмүүллийг магтан дуулсан бөгөөд феодалын нийгмийн ураг хуримын бурангуй ёс дэглэмийг эрс эсэргүүцсэн, хурц шүүмжилсэн өнгө аястай юм.

除此以外，元代著名的杂剧作家还有马致远、白朴、郑光祖、纪君祥等.元杂剧中的许多剧目一直到今天仍在戏剧舞台上上演，有的还被拍成了电影和电视剧，影响十分广

泛.18世纪，元杂剧《赵氏孤儿》曾流传到欧洲，被改编成《中国孤儿》，受到了世界的瞩目。

Бас Ма Жиюань, Бай Пү, Жэн Гуанзу, Зи Зюнь Сян нарын зэрэг алдартай жүжгийн зохиолчид Юан улсын үед төрж гарсан.

Дуулалт жүжгийн хөгжлийн түүхэнд хамгийн их үүрэг нөлөөтэй байсан урлагийн төрөл бол дээр өгүүлсэн эртний нанхиадын “ший янгу” бөгөөд эртний урлагийн энэхүү төрөл нь эдүгээ хятадын өмнөд нутгийн хэдхэн мужийн театрт улирлын болоод онцгой тохиолдлын чанартайгаар тоглодог болсон байна. Ер нь нийт хан үндэстний хувьд бүхэлдээ урлагийн өвөрмөц сонин уг төрлийг ойлгохоосоо ойлгохгүй нь дийлэнх бөгөөд “ший янгу” ч тэр эрт цагийнх шигээ хөгжих бус ер нь л зогсонги байдалтай, устах тал руугаа байгааг эрдэмтэн судлаачид өгүүлж байна.

Монгочуудын хувьд Юан гүрний үеийн дуулалт жүжгээс хойш ороо бусгаа цагийн давалгаанд дуулалт жүжиг нэгэнт мартагнаж, хожуу XIX зууны үед Говь мэргэн вангийн хошууны Ү Ноён хутагт Дулдуйтын Данзанравжаа “Саран хөхөөний намтар” хэмээх дуулалт жүжгийг монгол газарт, нүүдлийн ахуйд тохируулж өвөрмөц сонирхолтой байдлаар тавьж, тоглуулж олонд хүргэсэн байдаг. Монголын баруун хязгаар нутагт Засагт хааны хошуунд Лу жанжин гүн хэмээн алдаршсан шүлэгч Лувсандондов уугуул нутагтаа театрын үүсгэлийг хөгжүүлж улмаар “Өвгөн, шувуу хоёр” хэмээх дуулалт жүжиг тоглуулж байсан тухайд урлаг судлаач, эрдэмтэн Э.Оюун: “Түний энэхүү үйл ажиллагаа нь төвлөрсөн урлагийн газрын шинж үүслийн чанартай юм.” (УБ.1969.15-16) хэмээн өгүүлсэн байдаг. Асаатын хүрээг үндэслэгч ханчин ханбо хэмээн алдаршсан дуун ухаанч, эрдэмтэн Сүрэнхорын Жамъянгарав гэгээнтэн өөрийн дэргэд хөгжмийн хамтлагийг байгуулж, дууч хөгжимч, бүжигч нарыг мэргэшүүлж, цамын бүжгийг дэглэж, шинэ шатанд гаргаж тавьсан бөгөөд дээрхи хүмүүс Монголын утга, соёлын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Ийнхүү өртөөлж ирсэн дуулалт жүжгийн хөгжилд их Д.Нацагдорж “Учиртай гурван толгой” эмгэнэлт дуулалт жүжгээ туурвиж 1934 онд “Бөмбөгөр ногоон” хэмээх театрт анх тавьж тоглуулснаас хойш ардын дуунаас (Монгол ардын дуу “Цэнхэрлэн харагдана” дууны аялгуугаар дуулагдаж байсан) сэдэвлэсэн дуулалт жүжиг, нэлээд хожуу МУСГЗ Ж.Бадраа цомнолыг нь бичиж, Төрийн соёрхолт, Ардын жүжигчин Д.Лувсаншарав нар аялгуулан найруулж “Сүнжидмаа” ардын дуугаар сэдэвлэсэн дуулалт жүжиг тавьж 1981 онд гурван удаа тоглуулаад А.И.Цэдэнбал Филатовагийн үзэмжээр хаагдсан байдаг бөгөөд 1991 онд дахин тоглогдож эхэлсэн билээ.

Саяхан “Гоолингоо” дуунаас сэдэвлэсэн дуулалт жүжиг тавигдаж үзэгчдийн хүртээл боллоо. “Гоолингоо” дууны талаар өнөөгийн үзэгч, уншигчийн дийлэнх нь АЖ Д.Ичинхорлоо гуай 1937 онд алдарт уран зохиолч, хайрт хань нь болох Мөрдэндэвийн Ядамсүрэн хилсээр цаазлагдаж, цэл залуугаараа орчлонг орхисон тэр гунигт хар өдрүүдэд “Гоолингоо” дууг ханьдаа зориулж зохиож, дуулсан мэтээр ойлгодог ташаа ойлголт нэгэнт бий болсон байна. Үүнээс улбаалаад “Гоолингоо” дууг дуулсан хүний хувь заяа эвгүйцдэг, бүр бүтэлгүйтэж заавал бэлэвсэрдэг гэсэн нэг тийм сонин бодол, мухар сүсгийн үүднээс бий болсон байх юм. “Гоолингоо” хэмээх дуулалт жүжиг, найруулагч Соёлтын Баярсайханы найруулгаар тайзнаа амилж, Улаанбаатар чуулгын байранд 2012.10.10-15-ны өдрүүдэд тоглогдож нийтийн хүртээл болсон билээ.

Энэ удаад ч гэсэн “Гоолингоо” дуулалт жүжгийн талаар сэтгүүлч Л.Мөнхжаргал, жүжигчин Г.Отгонцэцэгтэй “Цагаанаас хар хүртэлх 99 саарал өнгөөр Гоолингоо амилна” гэсэн гарчигтай ярилцлага хийхдээ дээрхийг бас асуусан байх юм. Үүнд, **Л.М:**

Гоолингоо дууны талаар олон түүх байдаг. Мэдээж та энэ түүхүүдийг судалсан л байх. Хамгийн сонирхолтой нь ямар түүх байв? **Г.О:** Гоолингоо гэдэг нь “Гуулин гуа” гэсэн үгнээс гаралтай гэж үздэг түүх бий. Хятадын нэг судар номон дээр 1206 онд Чингис хаанд 50 сайхан Солонгос бүсгүйг татвар эм болгож өгсөн тухай тэмдэглэгдсэн байдаг юм билээ. Тухайн үед Солонгос улсыг гуулин улс гэдэг байсан шүү дээ. Гуа гэдэг нь мэдээж гоо сайхан гэсэн үг. Үүнээс улбаалаад Гоолингоог гуулин гуа гэсэн үгнээс үүсэлтэй гэж үздэг байна. Тэр 50 эмэгтэйн дурлалыг хагацаасан гэж бодохоор энэ дуу ариун хайрын тухай л дуу юм. Энэ түүх үнэний ортой байх. Ер нь Гоолингоогийн бүхий л түүхэн дээр үнэнч хайр дурлал, гансралын тухай өгүүлдэг юм билээ. Манай нэгэн үеийн агуу зохиолч Мөрдэндэвийн Ядамсүрэн гуай гучаад оны хэлмэгдүүлэлтийн золиос болоход Ардын жүжигчин Д.Ичинхорлоо гуай амрагаа мөрөөсөн санагалзан байхдаа энэ их уй гуниг харуусал шингэсэн аязыг өөрийн хоолойгоор пянзанд бичин үлдээсэн байдаг. Д.Ичинхорлоо гуайн дуулсан “Гоолингоо” дуу одоо ч хайр сэтгэл, хүслэн тэмүүллийн уянга болсоор л байна. **Д.М:** Гоолингоо хэзээ ч хүний сэтгэлд хүйтнээр тусдаггүй атал дуулсан хүнийх нь амьдрал бүтэлгүйтдэг зарим нэг хүмүүс ярьдаг. **Г.О:** Монгол хүн сэжгээр өвдөж, сүжгээр эдгэдэг гэж ярьдаг даа. Хүмүүс муу ёрын дуу, бэлэвсэн эмэгтэйн дуу л гэж ярьдаг юм. Тухайн хүн энэ дууг хэрхэн хүлээж авч байгаагаас л шалтгаална. (УБ.2012.10№2) гэсэн байна.

**Нэгэн зүйл:** 1206 онд эзэн Богд Чингис хаанд Солонгосоос 50 сайхан бүсгүйг татвар эм болгож авчирч өгсөн хийгээд тэр 50 бүсгүйн дурлалыг хагацаасан зэрэг асуудал бол ямар ч үндэслэлгүй юм. Учир нь, эзэн Богд Чингис хаан 1206 онд бүх монгол аймгийг нэгтгэж, Монголын тулгар их төрийг үндэслэсэн агуу их үйлийг бүтээсэн бөгөөд хэзээ ч Солонгос буюу Гуулин улс руу довтлоогүй. Бас Гуулин улсаас 50 гоо бүсгүйг эзэн Богд Чингис хаанд өргөн барьсан мэдээ занги үгүй байна.

**Нэгэн зүйл:** Хожим эзэн Богд Чингис хаан, хүү Өгэдэй нарын цэргийн жанжин Салита 1231 онд, ач хүү Хубилай сэцэн хааны үед 1274, 1281 онуудад Нихон улс, Солонгос буюу Гуулин улс, Ява Суматрийн арлууд руу монголын эзэнт гүрний их цэргийн хүчээр довтолж 1260-1380 оны хооронд 130 орчим жил Төвд, Тангуд, Манжуур, Солонгосын хойг, Филиппин, Малайзи, Ява Суматри зэрэг Зүүн өмнөд Азийг бүхэлд нь нэгтгэсэн хүчирхэг гүрэн оршин тогтнож байсан түүхтэй билээ.

**Нэгэн зүйл:** АЖ Д.Ичинхорлоо гуай 1933 онд “Гоолингоо” дууг Москвад пянзанд бичүүлсэн бөгөөд түүний хань зохиолч М.Ядамсүрэн 1937 онд хилсээр цаазлагдсан билээ.

“Гоолингоо” дууны талаар ардын урлаг судлаач, эрдэмтэд тусгайлан судалсан зүйл өнөө хэр үгүй байна. Монгол Улсын Төрийн хошой соёрхолт, ардын жүжигчин Н.Жанцанноровын хамтарсан “Гоолингоо” дууны талаарх нэвтрүүлэг нэгэнтээ олны хүртээл болсон билээ.

Бид энэ удаад “Гоолингоо” дууны утга, учрын талаар нэгэн санаа өгүүлэхийг зорьсон болно.

**Нэгэн зүйл:** Ардын жүжигчин Д.Ичинхорлоо “Гоолингоо”-г дуулж 1933 онд Москвад пянзанд бичүүлсэн байна. Уг пянз Монголын Театрын Музей-д хадгалагдаж байсан (АЖ Д.Ичинхорлоо гуайн охин И.Баямаа ээжийнхээ театрт байх үеийн дурсгалын зүйлүүдийг музейд бэлэглэсэн ажээ.) бөгөөд эдүгээ нэгэнтээ эвдэрч, сэргээгдэхгүй болжээ. Ингээд Монголын Радиогийн “Алтан хөмрөг”-т хадгалагдаж байгаа бичлэгт дуулснаар бичиж тэмдэглэж авлаа. Үүнд,

Зүүдээ нойрны минь дотор най

Зүрхний маань Гоолингаа үзэгдээд байнаа най  
Зүйчлээд захисан үгүүд нь бол най  
Миний маань цээжинд хадаатай байна най

Арван түмэн адуу нь бол най  
Арынхаа л ууландаа най алаглаад байна хө  
Амраг хонгор Гоолингаагийн алтан хүрээнээ хө  
Арынхаа ууландаа най цайрсхийгээд ирэх юм аа най ..., хэмээн шанз  
хөгжмөөр тоглож дуулсан байна.

**Нэгэн зүйл:** Профессор Г.Гунаажав (физикч), Р.Оюунбат (судлаач) нарын “Монгол ардын дуу” (УБ.2008.54) эмхэтгэл дэхь “Гоолингоо” дууны шүлгийг сонирхож үзье. Үүнд:

Зүүдээ нойрны минь дотор  
Зүрхний Гоолингоо минь үзэгдээд байх юм аа хө  
Зүйлчлээд хэлсэн үг чинь болвол доо  
Зүрхний маань гүнд хадаастайхан байх юм аа хө  
Арван түмэн адуун сүрэг нь хө  
Арынхаа улаанд алагласхийгээд байх юм аа хө  
Амраг Гоолингоогийн минь алтан хүрээ нь хө  
Арынхаа уланд цайрсхийгээд байх юм аа хө

Үй түмэн адуу нь болвол доо хө  
Өврийнхөө ууланд алагласхийгээд байх юм аа хө  
Үнэнч хайртай Гоолингоогийн минь хэлсэн үг нь хө  
Өөрийн минь цээжинд хадаастайхан байх юм аа хө ..., гэсэн байна.

**Нэгэн зүйл:** Монгол Улсын Урлагийн Гавьяат Зүтгэлтэн, ардын урлаг судлаач Солийн Цоодол агсан нэгэнтээ (1980-аад оны сүүлч) “Гоолингоо” дууны шүлгийн нэг л бадгийг хэлж бүр ямар аялгуугаар дуулдаг байсан тухай өгүүлснийг түүний шавь Р.Оюунбат тэмдэглэж авсан байна. Үүнд,

Амраг Гуалин гуагийн  
Алтан хүүр нь  
Арынхаа ууланд  
Арс хийгээд байхымаа хө ..., (УБ.2005.119) гэжээ.

Ардын урлаг судлаач Солийн Цоодол агсны тэмдэглүүлсэн ганц бадгаас мөшгөж үзвэл,  
Зүүдээ нойрны дотроо  
Зүрхний маань Гуалин гуа үзэгдээд байна  
Зүйлчлээд захисан үг нь бол хө  
Миний цээжинд хадаатай байна

Амраг Гуалин гуагийн  
Алтан хүүр нь  
Арынхаа ууланд  
Арс хийгээд байхымаа хө .

Үй түмэн адуу нь  
Өврийнхөө ууланд бэлчээд байна

Үнэнч Гуалин гуагийн алтан хүүр нь  
Өврийнхөө ууланд цайрхийгээд байхымаа хө ..., хэмээн  
дуулагддаг байсан бололтой юм. Тэгвэл найруулагч С.Баярсайханы “Гоолингоо”  
дуулалт жүжгийн тоглолтонд Гоолингоо хэмээх бүсгүй ийн дуулсан байх юм. Үүнд,

Зүүдээ нойрны минь дотроо най  
Зүрхний минь хүү най  
Үзэгдээд л байхымаа най  
Зүйчлээд хэлсэн үгэндээ  
Миний маань цээжин дээрээ  
Хадаастайхан байхымаа най  
Арван түмний адуун сүргээ най  
Арынхаа ууландаа най

Алагас хийгээд байхымаа най  
Амраг хүү маань  
Алтан хүрэнээ хөө

Арынхаа ууландаа цайрас хийгээд байхымаа най ..., хэмээн дуулагдлаа.  
Дээрхээс үзвэл “Гоолингоо” хэмээн нэрийдсэн уг дуу үндсэндээ дөрвөн хувилбар  
шүлгээр дуулагдаж байх бөгөөд эдүгээ нийтэд түгээмэл дэлгэрсэн нь дээрхи “Монгол  
ардын дуу” түүвэр дэхь тэр хувилбар болно. Үүнийг дараахь байдлаар нот-лсон байна.



Энэхүү шинэ хувилбарыг аялгуулсан хүн бол Монгол Улсын Төрийн Соёрхолт,  
хөгжмийн зохиолч Л.Мөрдорж юм.

Ардын урлаг судлаач Р.Оюунбат “Хүрээ дуу хөгжмийн үүсэл, хөгжил” хэмээх  
бүтээлдээ: “Чавганц багш” хэмээн алдаршсан Богдын дэргэдийн дуучин байсан  
Б.Лувсангомпил нь гуч гаруйхан настай байхдаа бэлэвсэрч, нөхрөө таалал болмогц  
сахил хүртсэн юм. Б.Лувсангомпил эр нөхрийнхөө хойноос хагацлын гунигт дуу  
“Гуалин гуа”-г зохиожээ.” (119) хэмээн тэмдэглэсэн байна. Энэхүү Б.Лувсангомпил нь  
Сүжигт гүний хошууны язгууртан Дэмчигваанжилийн хатан байсан талаар судлаачид  
өгүүлсэн байдаг.

Төв аймгийн Сэргэлэн сумын уугуул нэрт шанзчин С.Гомбо “Гоолингоо” дууг  
аялгууны хувьд дараах байдлаар аялгуулан хөгжимддөг байсныг түүний шавь судлаач,  
Р.Оюунбатын шанз хөгжмөөр аялгуулан тоглосныг сонсгож байна. Ингэхдээ бас  
аялгууг нь нот-луулж хавсаргалаа.

Andante



Өнөөдрийн байдлаар “Гоолингоо” хэмээн нэрийдсэн уг дууны шүлгийн дараах хувилбарууд байна. (дөрвөн хувилбарыг хавсаргав)

**1. МУСГЗүтгэлтэн С.Цоодлын хэлсэн нэг бадаг, түүний үргэлжлэл шүлэг**

Зүүдээ нойрны дотроо  
Зүрхний Гуалин гуа үзэгдээд байна  
Зүйлчлээд захисан үг нь бол хө  
Миний цээжинд хадаатай байна  
Амраг Гуалин гуагийн  
Алтан хүүр нь  
Арынхаа ууланд  
Арс хийгээд байхымаа хө .

**2. “Монгол ардын дуу” түүвэр дэхь шүлэг**

Зүүдээ нойрны минь дотор  
Зүрхний Гоолингоо минь үзэгдээд байх  
юм аа хө  
Зүйлчлээд хэлсэн үг чинь болвол доо  
Зүрхний маань гүнд хадаастайхан байх  
юм аа хө  
Арван түмэн адуун сүрэг нь хө  
Арынхаа улаанд алагласхийгээд  
байх юм аа хө  
Амраг Гоолингоогийн минь алтан хүрээ нь хө  
Арынхаа уланд цайрсхийгээд байх юм аа хө  
Үнэнч Гуалин гуагийн  
Алтан хүүр нь  
Өврийнхөө ууланд  
Цайрсхийгээд байхымаа хө  
  
Үй түмэн адуу нь болвол доо хө  
Өврийнхөө ууланд алагласхийгээд байх юм аа хө  
Үнэнч хайртай Гоолингоогийн минь хэлсэн үг нь хө  
Өөрийн минь цээжинд хадаастайхан байх юм аа хө ...

### 3. *АЖүжигчин Д.Ичинхорлоогийн дуулсан шүлэг*

Зүүдээ нойрны минь дотор най  
Зүрхний маань Гоолингаа үзэгдээд байнаа най  
Зүйчлээд захисан үгүүд нь бол най  
Миний маань цээжинд хадаатай байна най

Арван түмэн адуу нь бол най  
Арынхаа л ууландаа най алаглаад байна хө  
Амраг хонгор Гоолингаагийн алтан хүрээнээ хө  
Арынхаа ууландаа най цайрсхийгээд ирэх юм  
аа най

### 4. *Найруулагч Со. Баярсайхны “Гоолингоо” дуулалт жүжигт дуулагдсан шүлэг*

Зүүдээ нойрны минь дотроо най  
Зүрхний минь хүү най  
Үзэгдээд л байхымаа най  
Зүйчлээд хэлсэн үгэндээ  
Миний маань цээжин дээрээ  
Хадаастайхан байхымаа най  
Арван түмний адуун сүргээ най  
Арынхаа ууландаа най

Алагас хийгээд байхымаа най  
Амраг хүү маань  
Алтан хүрээнээ хөө  
Арынхаа ууландаа цайрас  
хийгээд байхымаа най...

Эндээс үүдээд “Гоолингоо” хэмээн нэрийдсэн дууны утга учир, өнгө аяс, аялгуу айзам, намба төрхийн тухайд өгүүлэхийн тулд дууны шүлгийн хувилбаруудыг зэрэгцүүлж нэлээд ажигласан болно. Юуны түрүүнд “Туалин гуа”, “Гуулин гуа”, “Гоолингаа”, “Гоолингоо” хэмээн нэрийдсэн байх юм. Мөн дууны шүлгийн шадын доторх үгсийн, агуулгын зөрүүтэй байдал илт байна. Ер нь, эртний нанхиадын оршуулгын зан үйлийн тухай алдарт, “Шижин” буюу “Шүлэглэлт ном”-ын дотор өгүүлсэн байдаг бөгөөд гашуудлын дуу, хагацлын дуу, өнчдийн дуу гэх зэргийг эдүгээ хүртэл гиншиж дуулсаар ирсэн уламжлалтай байна. Тэгвэл “Гоолингоо” хэмээн нэрийдсэн уг дууг энэ хүрээнд оруулж судлах нь зүйтэй бөгөөд уг дууны талаар дараах асуудлыг дэвшүүлж байна. Үүнд,

**Нэгэн зүйл:** Уг дуунд дуулагдаад байгаа хүний нэр болох “Гоолингоо”, “Туалин Гуа”, “Гуулин гуа”, “Гоолингаа”, “Гаолин Гао” гэдгийг чухам алинаар нь баримталж тайлбарлаж болох. Хэрвээ ханиасаа хагацаж бэлэвсэрч үлдсэн бүсгүй хүний гансарсан сэтгэлийн гунигт дуу гэдэг талаас нь үзвэл “Гаолин Гао” гэсэн нэр ихээхэн оновчтой байгаа бөгөөд “зүйлчлээд хэлсэн үг нь”, “захиж хэлсэн үг нь” гээд холбоод үзэхээр эр нөхрийнх нь үгс “цээжинд нь хадаастай”, “зүрхэнд нь хадаастай” үлдэж хоцорсон байгаа байдалтай байна. Тэгвэл “алтан шарил” нь “арын ууланд”, “өврийн ууланд” “арс хийгээд”, “цайрсхийгээд харагдаад, үзэгдээд байх юм” гэсэн нь шүтлэгийн улмаас оршуулгын зан үйлд бүрлээчийг ил тавьж нутаглуулдаг байсантай холбоотой бөгөөд үлдэж хоцорсон яс нь “арс хийгээд байна” эсвэл “цайрч харагдаж байгаа” байдлаар дүрслэгдэж өгүүлсэн байна.



**Нэгэн зүйл:** “Шижин” буюу “Шүлэглэлт ном”-д өгүүлснээр нанхиадын оршуулгын ёсонд эр нөхрөөсөө хагацсан эмэгтэйчүүд бэлэвсэрлийн үйлийг гүйцээх ёсон гэж байдаг бөгөөд энэ нь олон өдөр үргэлжилдэг байна. Бэлэвсэрлийн өдрүүдэд хятад эмэгтэйчүүд гашуудан гингэнэж уйлан, хагацлын дуу дуулдаг уламжлалтай юм байна. “Гоолингоо” биш “Gāolǐng Gāo ” буюу “Гаолин Гао” гэдэг нэр нь ихээхэн дүйж байна. Учир нь “Гоолингоо”, “Гоолингаа”, “Гуулин гуа”, “Гуалин гуа” зэрэг үгс нь аль нь ч үгийн утга дүйх талаар тохирохгүй байна. Харин “Gāolǐng Gāo” гэдэг үгийн утга учир нь, “Gāolǐng” гэдэг хятад хэлний үг нь ; **1.** өндөр настай, **2.** нас, сүүдэр өндөр, **3.** өндөр даваа, **4.** сайхан төрсөн эр хүн гэсэн дөрвөн утгыг агуулдаг байна. Тэгэхээр уг дуунд “алтан хүүр”, “амраг Гаолин Гао”, “үнэнч Гаолин Гао”, “арын уул, өврийн ууланд арс хийгээд, цайрсхийгээд байх юм” зэрэг үгс байна. Уг эх гэж үзэх бүрэн үндэстэй дараахь шүлгийн хувилбарт:

Зүүдээ нойрны дотроо  
Зүрхний Гуалин гуа үзэгдээд байна  
Зүйлчлээд захисан үг нь бол хө  
Миний цээжинд хадаатай байна

Амраг Гуалин гуагийн  
Алтан хүүр нь  
Арынхаа ууланд  
Арс хийгээд байхымаа хө .

Үнэнч Гуалин гуагийн  
Алтан хүүр нь  
Өврийнхөө ууланд

Цайрсхийгээд байхымаа хө., хэмээсэн нь уг дууны анхны утгыг бүрэн илэрхийлж байна. Учир юу вэ? гэвэл, шүлгийн шадын доторхи “арын ууланд арс хийгээд байгаа алтан хүүр” гэснийг “амраг Гоолингоогийн алтан хүрээ нь арынхаа ууланд цайрсхийгээд байна” гэж засварласан нь анхны утга болох “арын ууланд тавьсан алтан шарил нь арс хийх”, “өврийн ууланд тавьсан алтан хүүр нь цайрсхийх” биш, “алтан хүрээ нь цайрч харагдаад байна” гэсэн нь “хүүр, шарил” бус “хүрээ суурин” маягтай болж ангид өөр утганд шилжсэн байна. Мөн “арван түмэн адуун сүрэг”, “үй түмэн адуун сүрэг”, “өөрийн минь цээжинд хадаастай байна”, “арын ууланд алаглаж байгаа адуун сүрэг”, “өврийн ууланд алаглаад байгаа үй түмэн адуун сүрэг” гэсэн шинэ шадууд нэмэгдэж орсон байна.

**Нэгэн зүйл:** Бас эхний бадгийн 2 дахь шадын дотор байгаа “Зүрхний Гуалин гуа үзэгдээд байна”, эсвэл 2, 3-р бадгийн 1, 4-р шадын доторхи “Амраг Гуалин гуагийн”, “Үнэнч Гуалин гуагийн” бас “Арсхийгээд байхымаа хө, Цайрсхийгээд байхымаа хө.,” зэргийг авч үзвэл “өндөр настай Ли овогт” эсвэл “сайхан төрсөн эр хүн” гэсэн тайллууд дууны утга учиртай дараах байдлаар холбогдож байна. Эхнийх нь олон жил ханилсан хань нь насан эцэс болж хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн нэг утга, эсвэл сайхан эр хүн байсан бөгөөд цагаасаа эрт насан эцэслэж гэргий нь залуугаараа бэлэвсэрч хоцорсон уй гуниг, эр нөхрийнхөө хүүр цогцсыг оршуулсны дараа яс нь “арын ууланд арсхийж, өврийн ууланд царсхийгээд” харагдаад байгаа дараагийн утга тус тус илэрчээ.

**Нэгэн зүйл:** “Gāolǐng Gāo” буюу “Гоолингоо” хэмээн нэрийдэж дэлгэрсэн энэхүү дуу нь янаг амрагийн болоод хайр сэтгэлийн сэдэвтэй монгол ардын дуу биш бөгөөд гуниг хагацлын дуу төдийгүй тухайн цагт Их хүрээнд ирж суурьшсан нанхиад иргэдийн дунд дуулагдаж нийтэд дэлгэрсэн шинжтэй байна. “Гоолингоо” хэмээх нэрээрээ олонд түгсэн “Gāolǐng Gāo” гэдэг энэхүү дуу нь гашуудлын өнгө аяс бүхий гуниг хагацлын гунигт дуу болох юм.

## НОМ ЗҮЙ

1. Бадраа.Ж. “Монгол ардын хөгжим”. УБ.1998
2. Базаррагчаа.Ц. “Шижин”. УБ.1999
3. Гунаажав.Г. Оюунбат.Р. “Монгол ардын дуу”. УБ.2008
4. Данзанравжаа. Дулдуйт. “Саран хөхөөний намтар” дуулалт жүжиг. УБ.2003
5. Дашдорж.Д. Цоодол.С. “Ардын дуу хөгжмийн суу билигтнүүд”. УБ.1971
6. Дугаржав.М. “Монгол ардын дууны түүвэр”. УБ.1937
7. Загдсүрэн .У. “Монгол дууны судлалын товч тойм”. УБ.1975
8. “Сэдбазарын Лувсандондов гүн”. УБ.2001
9. Оюунбат.Р. “Хүрээ дуу хөгжмийн үүсэл, хөгжил”. УБ.2005
10. Пүрэвжав.С. “Хувьсгалын өмнөх Их Хүрээ”. УБ.1961
11. Хүрэлбаатар.Л. “судар шастирын билиг”.УБ.2002
12. Чимэд-Осор.Д. Цоодол.С. “Ардын дуунууд”. УБ.1959
13. О Китайском музыке.М., 1958

## SUMMARY

“Gāolǐng Gāo” is not a Mongolian folk song about love and romance. It is a song about sadness and sorrow that widely sung by the Chinese who settled in Ikh Khuree of that period. “Gāolǐng Gāo” known as “Гоолингоо” in Mongolian is a song of mourning.